

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

2021 оны 11 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу “Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ”-ний хүрээнд “Стандарттай төрийн үйлчилгээ” аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Менежмент ба ур чадварын хүрээлэн ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулж, орон нутаг дахь төрийн 56 байгууллагын 1341 албан хаагчийг хамруулсан. Сургалт, зөвлөгөөний үеэр 1 төрийн албан хаагчийг Төрийн албаны тэргүүний ажилтан цолоор, 10 төрийн албан хаагчийг Говьсүмбэрийн төлөө медалиар, 8 төрийн албан хаагчийг Засаг даргын жуух бичгээр тус тус шагнаж урамшуулж, төрийн албаны тусгай шалгалт өгөн төрийн захиргааны албан тушаалд томилогдон ажиллаж байгаа 5 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүллээ.

2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын дэмжлэгтэй хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөнд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 24 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, 21 ахуй үйлчилгээ эрхлэгч, 21 хоршоо, 32 худалдаа эрхлэгч, нийт 98 иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөлүүд оролцож, цаашид нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцсон байна.

2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Швейцарын хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны захирал Стеффани Бурри болон ажлын хэсгийн төлөөлөгчид орон нутагт ажиллаж, цаашид төрийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын чиглэлийн олон улсын байгууллага, гадаад улс орны дэмжлэгтэй төсөл хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, нийгмийн оролцогч талуудтай түншлэлийн харилцаагаа хэрхэн бэхжүүлж ажиллах талаар санал солилцсон.

аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Зээлийн гэрээ”, “Хууль зүйн туслалцааны төвийн танилцуулга, хуулийн зөвлөгөө” гэсэн сэдвээр 3 удаагийн цуврал подкаст бэлтгэн, цахимаар иргэдэд хүргэх ажлыг зохион байгууллаа.

2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын удирдах ажилтны нийт 13 сул орон тоонд тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн захиргааны удирдах албан тушаалын 2, төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны 1 сул орон тоо тус тус нөхөгдөөд байна.

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн албаны ерөнхий шалгалыг орон нутагт зохион байгуулж 55 иргэн оролцохоос 48 иргэн оролцож, 12 иргэн шалгалтад тэнцсэн бөгөөд шалгалтад тэнцсэн иргэдийн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгүүлэхээр шалгалтын тайлан, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ.

Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөхтэй холбогдуулан “Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ”-ний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн монгол бичгийн багш нартай хамтран төрийн захиргааны 117, албан хэрэг, бичиг хэргийн 52, нийт 229 албан хаагчийг анхан шатны сургалтад хамруулж, төрийн байгууллагуудад Монгол бичгийн программ хангамжийг ашиглах чиглэлээр арга зүйн заавар, зөвлөмж өгч ажиллаж байна.

2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар нийт халдварын тоо 5359, эдгэрсэн 5202, эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа 63 иргэн байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын 1 дүгээр тунд 12683, 2 дугаар тунд 12041, 3-р тунд 3968 иргэн хамрагдаад байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхааран ажиллаж байна.

2021 оны 11 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 5,158.013 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5,588.480 мян.төгрөг төвлөрүүлж, 109 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 1,116.009 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,116.009 мян.төгрөг төвлөрүүлж, 100 хувь, сумын төсвийн орлогод 786.282 мян.төгрөг төвлөрүүлэхээс 997.386 мян.төгрөг төвлөрүүлж, 127 хувь, аймгийн төсвийн орлогод 5,158.013 мян.төгрөг төвлөрүүлэхээс 5,588.480 мян.төгрөг төвлөрүүлж, 109 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Татварын хэлтсээс 2 аж ахуй нэгжид 2017-2020 оны татвар, санхүүгийн баримт материал, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 281,212,975 төгрөгийн зөрчил илрүүлэн 18,882,155 төгрөгийн нөхөн ноогдуулалтын акт үйлдэн ажилласан.

Статистикийн чиглэлээр: Хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүний үнийн ХАА-3, ургац хураалт хадлан тэжээлийн ХАА-8, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн ХАА-10 мэдээг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн АҮ-1 мэдээ, хэрэглээний бараа үйлчилгээний үнийн Үнэ-21 мэдээ, 7 хоногийн үнийн мэдээ мэдээллийг хугацаанд нь тус тус Үндэсний статистикийн хорооны төв серверт дамжуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг зохион байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 654 ААНБ бүрэн хамрагдсан бөгөөд тооллогын ажил 100 хувьтай байна.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Аймгийн төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2021 оны 10 сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 96.7 хувь буюу өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.11.25		2021.11.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/
1	Өндөр настан	1837	8049911,6	1942	9806308.4
2	Хөгжлийн бэрхшээлтэй	334	1199008,9	343	1148790.5
3	Тэжээгчээ алдсан	131	407044,3	125	461810.3
4	Үйлдвэрийн осол	27	137570,8	44	266854.0
Нийт дүн		2329	9793535,6	2454	11683763

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.11.25		2021.11.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	1137	155407,1	1524	194791.1
2	ЖБА тэтгэмж	331	588035,1	426	866858.6
3	Оршуулга	60	60000,0	91	91000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	7	6306	14	13024.8
5	Ажилгүйдэл	164	346461,0	207	351929.8
Нийт дүн		1699	1156209,2	2262	1517604.3

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.11.25	2021.11.25
Шинээр	325	237
Мөнгө тушаасан	504	558
Тушаасан мөнгөн дүн / мян.төг/	108357,5	193552.2

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 14
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 11
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 31
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 12
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 22
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 17

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 7
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 43
- Гэрээний бүртгэл - 65
- Барьцааны гэрээний бүртгэл - 157
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга – 7

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 3
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 8

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 8
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 11
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 153

Аймгийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сард иргэний бүртгэлийн чиглэлээр 110, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 279, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 11, архивын чиглээр 172, нийт 572 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс: 2021 оны 11 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 105 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 33, зөрчлийн 72 гомдол мэдээлэл байна. Тайлант хугацаанд зөрчил гаргасан 37 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 4,905,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 76 хүнийг эрүүлжүүлж, 21 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 30 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, гудамж талбай, олон нийтийн газар, автозамд зөрчил гаргасан 2270 хүнийг 81,074,000 төгрөгөөр торгосон.

Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Аргаль ойл”, “Гаалийн хяналтын бүс”, “Говь урал”, “UB trans”, “Улсын нөөцийн салбар” зэрэг аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа, хяналтын камерын хэвийн ажиллагаанд шалгалт хийж ажиллалаа.

Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурагчдад "Үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нь", "Дэлгэцийн донтолт", "Зөв хандлага, төлөвшил", "Хүүхдийн эрх", "Гэр бүлийн хүчирхийлэл" гэсэн сэдвээр сургалт зохион байгуулж, 69 сурагчийг хамруулсан.

“Мал мах-2021” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хөдөөгийн малчин, мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа, ухуулга, сэрэмжлүүлэг хийж, холбогдох санамж, зөвлөмж, сэрэмжлүүлэг материалыг тарааж ажиллав. Баянтал, Шивээговь сумдад эргүүл, постуудыг ажиллуулж, гарал үүслийн бичиггүй мал, мах тээвэрлэж явсан 5 зөрчил илрүүлж, 750 нэгжээр торгож арга хэмжээ авсан байна.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 13 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 2, зам тээврийн ослын 4, хулгайлах гэмт хэрэг 3, бусад хэргийн газрын үзлэгт 4 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 299 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д заасны дагуу “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт” зохион байгуулах ажлын хүрээнд согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хүмүүжигчдийн албадан

сургалтанд 11, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүжигчдийн албадан сургалтанд 3, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын албадан сургалтанд 7 хүмүүжигч хамрагдсан. Мөн суллагдах дөхөж буй 25 хүмүүжигчийг сургалтанд хамруулж байна.

2021 оны 11 дүгээр сард төлбөрийн 238 гүйцэтгэх баримт бичгийн 365,0944.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 114 гүйцэтгэх баримт бичгийн 917,111.0 мян.төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 47.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мэргэжлийн хяналтын газар: Баянтал сумын эрүүл мэндийн төвийн коронавирус /ковид-19/-ын эмчилгээний тасагт дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Хяналтаар эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмтэй холбоотой 10, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт, эмчилгээний чанар, стандарт удирдамжийн мөрдөлттэй холбоотой 8, эм тарианы нөөц хангалттай холбоотой 1 буюу нийт 19 зөрчил илрүүлж, 4 зөрчлийг газар дээр нь арилгуулан 15 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Коронавирус /ковид-19/ цар тахлын халдвар хамгааллын дэглэмтэй холбоотой 10 объектод шалгалт хийж, 6 зөрчил илрүүлэн, шалгалтын явцад зөрчлийг 100 хувь арилгуулсан.

Говьсүмбэр аймагт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг цахилгааны эрчим хүчний 3, дулааны эрчим хүчний 4, нийт 7 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар газар дээр нь заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр 2 объектод төлөвлөгөөт шалгалт хийж, 46 зөрчил илрүүлж, 3 зөрчлийг газар дээр нь арилгуулан, 36 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

2021 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Энхбилэг эмнэлэг, Баянтал, Сүмбэр сумдын эрүүл мэндийн төв, Шивээ-Овоо ХК-ийн эмнэлгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, эмбиобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, чанар аюулгүй байдал, тусламж үйлчилгээнд хяналт тавьж, 3 байгууллагад 24 заалттай албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангасан.

Мөн 11 объектод 5 төрлийн хяналтын хуудсаар төлөвлөгөөт шалгалт хийж, 63 зөрчил илрүүлэн, 28 зөрчил буюу нийт зөрчлийн 44 хувийг шалгалтын явцад арилгуулж, 24 зөрчлийг арилгуулахаар 5 байгууллагад албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хүнсний чанар, стандартын хяналтын болон эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн усны 32, хүнсний бүтээгдэхүүний 38, ундааны 7, арчдас 89, агаарын 4, ариун материалын 11, бассейны 7, хөрсний 5, бохир усны 2, махан бүтээгдэхүүний 3, нөөшилсөн бүтээгдэхүүний 2, хоол амтлагчийн 7, хоолны 14, нийт 221 сорьцонд 603 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж, гүйцэтгэсэн.

Онцгой байдлын газар нь: Аймгийн Засаг даргын баталсан “Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө”-ний дагуу Баянтал суманд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулж, Баянтал сумын шуурхай штаб, мэргэжлийн анги, иргэдийн нөхөрлөл, бүлгүүдийг чадавхжууллаа.

Мөн ерөнхий боловсролын 1, 5 дугаар сургууль, Хаан банк, Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, газар хөдлөлт, гал түймэр, үер усны осолд авч хэрэгжүүлэх ажил, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 89 ажилтан, албан хаагчийг хамруулсан.

11 дүгээр сарын 5-15-ны өдрүүдэд Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төр захиргааны байгууллагуудад хяналт, шалгалт зохион байгуулж, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье” төлөвлөгөөт хяналт, шалгалтыг Сүмбэр сум 1, 2, 3 дугаар багт зохион байгуулж, 1527 айл өрхийг хамруулан 563 зөрчлийг илрүүлснээс 124 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 439 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч, 3317 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа хийж ажиллалаа.

Халаалтын нам даралтын уурын зуух ашигладаг 29 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжид галын аюулгүй байдлын тухай хууль стандарт норм нормативын

хэрэгжилтийг хангуулах зорилгоор төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг зохион байгуулж, арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажилласан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран “Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх” сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 20 багш, ажилтныг хамрууллаа.

“Боловсролыг дэмжих 2021 оны арга хэмжээ”-ний хүрээнд байгалийн ухааны хичээлийг заах арга зүйн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн хими, физик, биологийн 19 багшийг хамруулсан.

Монгол Улсын Гавьяат багш, “Хүмүүн бичиг” сонины нарийн бичгийн дарга Б.Элбэгзаяатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичгийн багш нарт “Монгол бичиг хялбар сурах арга зүй” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж өгсөн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Аймгийн “Гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд Монгол Улсад Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан “Оролцоод-манлайлъя” аймгийн залуучуудын цахим чуулганыг 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулан, 136 залуу үеийн төлөөллийг хамрууллаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Баянтал сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2021 оны 11 сарын 5, 6-ны өдрүүдэд “Залуус бидний оролцоо-2021” Баянтал сумын залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулан, “Шинэ санаа-залуусын дуу хоолой” хэлэлцүүлгийг хийсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Зэвсэгт хүчний Жанжин Штаб, Эерэг тэмүүлэл төрийн бус байгууллагатай хамтран Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Орчин цагийн зэвсэгт хүчний байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан орон даяар зохион байгуулагдсан “Эх оронч залуу” үндэсний аяны хүрээнд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, ШШГГ 425 дугаар нээлттэй хорих ангийн 102 алба хаагчдад “Эх оронч залуу” сургалтыг зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээлэл, арга зүйгээр хангах, мэргэжил сонголтоо зөв хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад “Мэргэжил сонголт-миний ирээдүй” сэдэвт сургалт зохион байгуулж, 28 хүүхдийг хамруулан, мэргэжлийн хэв шинжийг тодорхойлох тест оношилгоо хийж хүүхэд бүрийн мэргэжлийн хэв шинжийг тодорхойлон тохирох мэргэжлийн чиглэлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.

Соёл, урлагийн чиглэлээр: Дуу бүжгийн “Боржигин чуулга” Монгол улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Мөнхөд үргэлжлэх бидний удам угсаа минь” сэдэвт Угийн бичгийн үзэсгэлэнгийн нээлтийг байгуулж, танхимаар 45 хүн, цахимаар 239 хүн, нийт 284 хүнд үзүүлж өв соёлын мэдлэг олгосон.

Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн “Хан хэнтий” чуулгаас зохион байгуулсан Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Д.Гомбо агсны нэрэмжит хөгжмийн цахим уралдаанд аймгийн “Боржигин чуулга”-ын хөгжим ангийн уран бүтээлчид оролцож тэргүүн байр эзэлсэн.

Соёлын яамнаас 11 дүгээр сарыг “Соёлын бүтээлч сар” болгосонтой холбогдуулан дуу, бүцгийн “Боржигин чуулга” 2021 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл “Жинчид ирлээ” ардын дууны тоглолт, “Хөглөхүй” хөгжим ангийн уран бүтээлчдийн тоглолтыг тогтмол зохион байгуулж байна.

“Боржигин өв” музей 11 дүгээр сард танхимаар 235 хүнд соёлын үйлчилгээ үзүүлсэн. Мөн угийн бичгийн сургалтыг зохион байгуулж, 21 байгууллагын 517 албан хаагч, 355 хүүхдийг хамруулаад байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2020 оны 11 сарын 20	2021 оны 11 сарын 20
Төрсөн эх	400	422
Гэрийн төрөлт	0	3
Амьд төрсөн хүүхэд	405	429
Амьгүй төрөлт	0	1
Нас баралт	64	77
Эмнэлгийн нас баралт	3	28
Хоног болоогүй нас баралт	1	6
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	4008	5838
Амбулаторийн үзлэг	87137	84264
Халдварт өвчин	69	4623

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Коронавируст халдварын хариу арга хэмжээний хүрээнд чадавхжуулах сургалтыг "Стресс менежмент, нойргүйдэл", "Стрессийг эерэг, зөв аргаар даван туулъя" сэдвээр зохион байгуулж, 110 хүнийг хамруулсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл", "Хууль эрх зүйн орчин", "Нэг худалдан авагчийн тогтолцоо, стратегийн худалдан авалтын концепц", "Эмнэлгийн хагас бие даасан байдлын тогтолцоо", "Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн сангаас тусламж үйлчилгээний багц тодорхойлох арга зам" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, 65 албан хаагч хамрагдлаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг "Эм Эс Деволепмент" ХХК сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын зорилтот бүлгийн нийт 87 иргэнийг хамруулсан.

2021 оны 11 дүгээр сард шинээр байнгын 6 ажлын байр бий болсон бөгөөд өссөн дүнгээр 120 шинэ ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Залуучуудын оролцоо төсөлд хамрагдсан 24 иргэнээс байнгын ажлын байранд 13 иргэнийг зуучилсан.

"Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ" арга хэмжээний хүрээнд 5 байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж, 14 ахмад мэргэжилтэн түр ажлын байраар хангагдаж, мэдлэг, ажлын туршлагаасаа залуу хойч үеийнхэнд зааж сурган, өвлүүлэхээр төслийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2021 оны 10 сарын байдлаар 17 удаа хуралдаж, 37 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл 85.4 хувь, Засгийн газрын 221 дүгээр тогтоолын дагуу аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 100 хувь, сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 71 хувь, малын усан хангамж 94.8 хувь, малчин өрхийн хашаа, хорооны бэлтгэл 83.3 хувь, өрхийн өвлийн бэлтгэл 88.7 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 682 малчин өрх 5571 тн өвс, 381 тн гар тэжээл, 1130 тн үйлдвэрийн тэжээл, 40 тн ногоон тэжээл, 589 тн хужир бэлтгэсэн. Малчин өрхийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт 74.2 хувь, малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл хангалт 88.7 хувьтай байна.

"Бэлчээр хамгаалах улирал" аяныг зохион байгуулж, тусгай хамгаалалтын бүсээс гадагш 24.3 га бэлчээрийг чөлөөлөхөд 20 малчин өрх өвөлжөө, хаваржааны бэлчээрээ чөлөөлж хамгаалах, сайжруулах арга хэмжээнд оролцсон.

Тэжээлийн нэг болон олон наст ургамлыг бууцны хөлд тариалуулахаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаар 3 төрлийн таримлын үрийг 12 малчин өрхөд олгон, арга

зүйгээр ханган ажилласны үр дүнд 10 малчин өрх 0.5 га-д тариалалт хийж 0.25 тн ургац хураан авсан.

Баянтал, Сүмбэр сумын Засаг дарга, Мал эмнэлгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран отрын пост гаргаж отрын малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

Малын чанар сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилгоор бог малын зохиомол хээлтүүлгийн ажлыг 2 дахь жилдээ зохион байгуулж, махны чиглэлийн Эдельбай үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үр болон Барга үүлдрийн хуцнаас үр авч 80 хувийн техник гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ.

2021 оны 11 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд Дорноговь аймагт зохион байгуулагдсан “Бизнес ба хүний эрхийг хангах” нь бүсийн зөвлөгөөнд орон нутгийн бизнес эрхлэгч 12 иргэн, ААНБ-ын төлөөллийг хамрууллаа.

Мөн 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр орон нутгийн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчдэд хоршооны тухай хуулийн талаарх мэдээлэл өгч, шинээр хоршоо байгуулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, 21 иргэн хамрагдсан.

2021 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр 26.1 га талбайгаас 232.08 тн төмс, 25.84 га-аас 218.3 тн хүнсний ногоо, 11.4 га-аас 35.2 тн тэжээлийн ургамал хураан авсан байна. Энэ нь өмнөх онотой харьцуулахад хураасан талбайн хэмжээ төмс 8.5 га, хүнсний ногоо 26.4 га-аар, хураан авсан ургацын хэмжээ төмс 72.68 тн-оор, хүнсний ногоо 27.1 тн-оор тус тус нэмэгдсэн байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 11 дүгээр сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 250-5000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /цул/ 1000 төгрөгөөр, Хонины ястай мах 250 төгрөгөөр, Адууны ястай мах 1000 төгрөгөөр, адууны цул мах 500 төгрөгөөр, Лууван 300 төгрөгөөр, Чинжүү 1500 төгрөгөөр, помидор 3000 төгрөгөөр, өргөст хэмх 4000-5000 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /10-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	11000	9000	-
		Цул	13000	11000	+1000
2	Хонины мах	Ястай	9000	8000	+250
		Цул	11000	10000	-
3	Адууны мах	Ястай	8500	8000	+1000
		Цул	9000	8500	+500
4	Ямааны мах	Ястай	7000	6500	-
		Цул	8500	8000	-
5	Лууван	монгол	2200	1500	+300
		хятад			
6	Төмс	монгол	1400	600	-
		хятад			
7	Байцаа	монгол	2000	1800	-
		хятад			-
8	Чинжүү	монгол	13000	11000	+1500
		хятад	13000	1100	
9	Манжин	монгол	2000	1800	
		хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	3800-	1500	-
11	Помидор	монгол	13000	8000	+3000
12	Өргөст хэмх	монгол	15000	12000	+4000-5000
13	Элсэн чихэр	монгол	3000	2300	-
		Цагаан задгай кг	3000	2400	-

14	Будаа	Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	1200	1150	-
18	Өндөг	Монгол	550	430	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
20	Ургамлын тос	Олейна	8800	7500	-
		Алтан	6500	4500	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан “Ойн салбарын үндэсний чуулган”-д орон нутгаас 12 төлөөлөгч оролцож, аймгийн Засаг даргаас 5.0 сая мод тарьж, ургуулахаа илэрхийлэн батламжид гарын үсэг зурлаа

“Тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн сурагчдад байгаль эх дэлхийгээ хайрлаж хамгаалах, зөв хандлага төлөвшүүлэх, зарим хог хаягдлыг дахин ашиглаж бүтээл хийх зэрэг сургалт зохион байгууллаа.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2 иргэн, 1 аж ахуйн нэгжийн төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж дүгнэлтийг хүргүүлсэн.

Орон нутгийн хэмжээнд усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулан, аймгийн хэмжээнд булаг 20, нуур 9, гол 6, баянбүрд 1, хөв цөөрөм 3, газрын доорх цэнгэг усны орд газар 7, худаг 435 тус тус байгааг тоолж, бүртгэлжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран зохион байгуулсан “АйТиЭм-2021” буюу “International Travel Mart 2021” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас 8 төр, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллийг оролцуулж, аялал, жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан.

Чойрын богд уулын улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газрыг өргөтгөхтэй холбоотой аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 7-ны 04 дүгээр тогтоол болон холбогдох материалыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанд оруулахаар өргөн мэдүүлсэн.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс 11 дүгээр сард найман хугацааны мэдээг нийт 240, климат агро дундаж мэдээ ХАА-н тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Тайлант сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 39 удаа, мөн шинжилгээг 13 удаагийн дээжинд хийж, дундаж азотын давхар исэл (NO₂) 0.013 мкг/мг, сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.017 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Газрын харилцааны үйлчилгээг 2021 оны 10 дугаар сарын 01-ээс эхлэн цахимжуулсантай холбогдуулан цахим ажил үйлчилгээг www.egazar.gov.mn болон EGAZAR ухаалаг гар утасны аппликейшныг сурталчлан, “Газрын харилцаа-цахим үйлчилгээ” сэдэвт сарын аяныг зохион байгуулсны үр дүнд 35 иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэж, 15

байгууллагын 186 албан хаагчдад мэдээлэл хүргэж, 386 ширхэг гарын авлага тарааж, 69 иргэний гар утсанд аппликейшн суулгах зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн хэмжээнд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 2020 оноос өмнөх оны газрын өр төлбөр болох 56.3 сая төгрөгийг барагдуулах ажлыг эрчимжүүлж Говьсүмбэр аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 29 иргэн, аж ахуйн нэгжид нэхэмжлэл гаргасны үр дүнд нийт 39.3 сая төгрөгийн өрийг төвлөрүүлэн барагдуулаад байна.

Дуудлага худалдааг газрын биржийн цахим систем (www.mle.mn)-ээр дамжуулан тогтмол зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 4 байршилд, сумын Засаг даргын захирамжийн дагуу 3 байршилд тус тус дуудлага худалдааг зарлаад байна.

Худалдан авах ажиллагааны талаар: 2021 онд нийт 6,811,701.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 62 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 42 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 19 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 7 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 8 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 8 ажил, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлан, 42 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх 1 ажлын худалдан авалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулан ажиллаж байна.

2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын гүйцэтгэлийг дүгнэхэд 48.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрөхөөс 36.0 сая төгрөг төвлөрч, 74 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 89.1 хувьтай байна. Малхын отрын бүс нутагт өвөлжих Дундговь аймгийн Говь-Угтаал, Төв аймгийн Сэргэлэн сумын 31 өрхийг дамжуулан өнгөрүүлсэн бөгөөд УБТЗ ХНН-ийн харьяа 16 дугаар зөрлөг дээр мал эмнэлгийн хяналтын постыг ажиллуулж, малын шилжилт хөдлөгөөнд хяналт тавин ажиллаж байна. Дундговь аймгийн 4 сумаас 5 малчин өрхийн 7090 мал отроор өвөлжиж байна.

Шивээговь сум: Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт”-ын магадлах аудитыг цахимаар хийлгэж, баталгаажуулалтын гэрчилгээгээ хадгалах эрхтэй болсон.

E-mongolia системийн оператораас төрийн 54 нэр төрлийн үйлчилгээг өссөн дүнгээр 425 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжийн дансанд 309200 төгрөгийг төвлөрүүлээд байна.

Иргэдийг малжуулах арга хэмжээний хүрээнд 4 өрхөд тус бүр 30 хонь, 20 ямаа, нийт 200 толгой бог малыг 1 жилийн хугацаатай олголоо.

Сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/157 дугаар захирамжаар “Эргүүл хяналт шалгалт”-ын ажлын хэсэг томилогдон Шоовойн говь, найман шороот, Бөгсийн ар, зүйтийн тал, тогоо булаг, хар ам, Нүхэн сондуул, Хаялага нуур гэсэн маршрутаар нийт 200 гаруй километр газарт зохион байгуулж, 23 өрхөд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч, гарын авлага тараасан.

Сүмбэр сум: Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм баримталж ажиллах, ажилтан, албан хаагчдаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дархлаажуулалтын сэргээх нэмэлт тунд хамруулах тухай зөвлөмж, мэдээлэл өгч ажиллаж байна. Одоогийн байдлаар 70 аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нартай хариуцлагын гэрээ байгуулаад байна.

Нийтийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд архи дан согтуурч гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 20 иргэнийг Дорнод аймгийн “Сэтгэцийн наркологийн ухаарал” эмнэлгийн эмчилгээнд хамрууллаа.

Сум хөгжүүлэх санд зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчийн материалыг харъяа шүүхийн байгууллагад бүрдүүлж хүргүүлсэн. Одоогоор сум хөгжүүлэх санд нийт 339.1 сая төгрөг төвлөрөөд байна.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**